

# **Багийн ажил: Бэлтгэсэн зургууд бидэнд юу хэлж чадах вэ?**

Дасгал ажлын танилцуулга

# Зорилтууд

1. Урьдчилан бэлтгэсэн зурганд санал, удирдамж өгөх
2. REDD+-н төлөвлөлттэй холбоотой түлхүүр дүгнэлтүүдийг гаргахад газрын зураг хэрхэн ашиглагдаж болох талаар ойлголттой болох

# Алхамууд

## 1-р алхам - зохион байгуулах

Дөрвөн баг болгон хуваагдах:

1. Ойн бүсийн зураг: ойн боломжит нөлөөлөл
2. Ойн бүсийн зураг: олон талт боломжит үр ашиг
3. Төв аймгийн газрын зураг
4. Хөвсгөл аймгийн газрын зураг



## 2-р алхам - Анхны сэтгэгдэл

Баг тус бүр өгөгдсөн газрын зурагныхаа дагуу асуултанд хариулж, хариултаа хананд наана:

- Энэ зургийн юу нь таньд таалагдаж байна вэ?
- Санал нийлэхгүй эсвэл таалагдахгүй байгаа зүйл байна уу?
- Энэ зургуудыг юунд ашиглаж болох вэ?



## 3-р алхам – Газрын зургаа солилцох

Багууд байраа солино:

- 1,2 р баг (Ойн бүсийн зураг) солигдоно
- 3,4 р баг (Төв, Хөвсгөл аймаг) солигдоно

Баг тус бүр нөгөө багийн хариулсан хариултуудыг хараад дээрх гурван асуултанд өөрийн хариултыг нэмж болно.



## **Алхам 4: Өөрсдийн хийсэн зураг руу буцах**

Дараа нь тайлагнахдаа бэлдэж дараах 2 даалгаварыг хэрэгжүүлнэ:

### **1. Нэмэлт асуултанд хариулах:**

- 1,2-р багийн асуулт: Аль газар ойн хомсдол болон ойн олон талт үр ашгийг харуулж байна вэ? Ойн бүрхэвчийн зурган дээр эдгээрийг дугуйлаад яагаад гэдгээ бичнэ.
- 3, 4 -р баг: Аль ойтой талбай нь олон төрлийн ойн үр ашгийг өгч байна вэ? Тэдгээрийг ойн төрлийн зурган дээр дугуйлаад ямар үр ашгийг өгч байгааг тэмдэглэнэ.

### **2. Гурван түлхүүр дүгнэлтүүдийг бичих :**

цагаан цаасан дээр эдгээр өгөгдсөн зурагнууд юу хэлж байгаа талаар 3 түлхүүр дүгнэлт бичнэ. Энэ нь газрын зураг нь юуг харуулж байгаа талаар эсвэлилүү судалгаа шинжилгээ хийх шаардлагатай асуултууд ч байж болно.

# *5-р алхам - Цайны завсарлага*



## 6-р алхам - Тайлагнах

Алхам 4-т хийсэн сүүлийн 2 даалгавараа тайлагнах хүнээ сонгоно:

1. Сонгосон газар
2. 3-н тулгуур дүгнэлт

